



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 605

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэгийн 2019 оны эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар нийт 47.9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэгийн 2019 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэгийн захирал /Ц.Төмөр-Очир/-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай;

2.1. Барилга болон автомашины ашиглалтын хувийн хэргийг холбогдох журмын дагуу тогтмол хөтөлж, хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг зөв тооцож, бүртгэл хөтлөх;

2.2. Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах;

2.3. Төрийн эзэмшлийн газар дээр зөвшөөрөлгүй барьсан барилга байгууламжийг буулгаж, төрийн эзэмшил газрыг чөлөөлөх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

2.4. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө гарган, биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн
625 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Эрүүл мэндийн хүрээлэнд зөвшөөрөлгүй ашиглуулсан 412 м2 төрийн өмчийн талбайн ашиглалтын зардал	Захирал Ц.Төмөр-Очир, Санхүү бүртгэлийн албаны дарга З.Отгон	47.9	-Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам", -Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай" 119 дүгээр тогтоол	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах